

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2021.01.25 № 9/227
танай _____-ны № _____-т

Үүрэг даалгавар өгөх тухай

Хорооноос 2021 онд үнэт цаасны зах зээлд эрсдэлд суурилсан хяналт, зайны хяналт, шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, үнэт цаас гаргагч буюу хувьцаат компанийн үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг бууруулах бодлогыг баримтлан ажиллаж байна.

Энэ хүрээнд дараах хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. Хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасан шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 онд зарлан хуралдуулах ажлыг зохион байгуулахдаа дараах шаардлагыг хангаж ажиллах:

- 1.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргаснаас хойш гурав хоногийн дотор Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралтын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлэх;
- 1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг компанийн ерөнхий захиргаа байрлаж байгаа газраас өөр газарт хуралдуулахаар товлосон бол хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн хамгийн их төвлөрөлтэй, аливаа зардал, чирэгдэлгүйгээр оролцох боломжтой газарт хурлыг хуралдуулах;
- 1.3 Коронавируст халдварт өвчин /Ковид-19/-ний тархалттай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахдаа хувьцаа эзэмшигчдийг нэг дор цугларуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийн ашиглан хуралдуулах өөрийн онцлогт тохирсон боломжтой хэлбэрээр зохион байгуулах;
- 1.4 Цахим хурал хуралдуулах мэдээллийн технологи нь хувьцаа эзэмшигчдэд хэрэглэхэд амар ойлгомжтой, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангасан талаарх танилцуулгыг Хороонд ирүүлэх,
- 1.5 Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалттай нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр холбогдох баримт материалыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн

- 20.1.8-д заасан хугацаанд буюу хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор Хороонд ирүүлэх;
- 1.6 Мөн хуулийн 59.11, 96.4 дэх заалтуудтай тус тус нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 1.7 Мөн хуулийн 79.3.3 дахь заалттай нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гарсан шийдвэрийн талаар мэдээлэл өгөх, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх үүргээ биелүүлэх;
- 1.8 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд нь мөн хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хараат бус гишүүдээр бөглүүлэн ирүүлэх;
- 1.9 Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т “Нэр дэвшүүлэх хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний нэрийг дэвшүүлнэ” гэж заасны дагуу нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийг ирүүлэх ба төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын сургалтад сууж, гэрчилгээ авсан байх;
- 1.10 Компанийн тухай хуулийн 77.5-д “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно” гэж заасны дагуу хараат бус гишүүнийг түр томилсон тохиолдолд нэн даруй Хороонд мэдэгдэж, тухайн ТУЗ-ийн гишүүний дэлгэрэнгүй анкет болон хараат бус гишүүний шаардлага хангаж байгаа эсэх нотлох баримтын хамт ирүүлэх;
- 1.11 Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2 дахь заалтыг тогтмол хэрэгжүүлэх;
- 1.12 Компанийн нийт гаргасан хувьцааны 5 хувь түүнээс дээш хувийг эзэмшигчдийн бүртгэл болон нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлийг ирүүлэх;
- 1.13 Хорооны 2020 оны 880 дугаар тогтоолоор “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журмыг шинэчлэн батлах тухай” баталсан бөгөөд уг журамд заасны дагуу санал хураалтыг хэрэгжүүлэх;
- 1.14 “ҮЦТХТ” ХХК-аас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй жагсаалтыг бүртгэлийн өдрөөр гаргаж ирүүлэх /тархалтын судалгаа/.
2. Хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах:
- 2.1 Компанийн үйл ажиллагааны тайлан болон компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлага зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой мэдээллийг тус журамд заасан хугацаанд болон өөрчлөлт орсон тухай бүр журамд заасны дагуу мэдээлэх;
- 2.2 Журмын хэрэгжилтэд хөрөнгийн бирж хяналт тавьж ажиллахаар зохицуулагдсан тул холбогдох мэдээллийг компанийн цахим хуудас болон хөрөнгийн биржийн цахим

хуудсанд байршуулах үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захиралд үүрэг болгож хөрөнгийн биржтэй хамтран ажиллах.

3. Хорооны 2020 оны “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоолоор ногдол ашгийг компани дээрээ олгодог, ногдол ашгийг жил дамнуулан хуваарилдаг байдлыг зогсоож, ногдол ашгийг тухайн жилд багтаан “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчийн дансанд шууд байршуулж байхыг хувьцаат компаниудын удирдлагад үүрэг болгосны дагуу Компанийн тухай хуулийн 46.5-д заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн эсэх мэдээлэл, хэрэв шийдвэрлэсэн бол “ҮЦТХТ” ХХК-тай гэрээ байгуулж, холбогдох баримтыг тус тус ирүүлэх, ногдол ашиг тараах шийдвэрт Компанийн тухай хуулийн 46.1-т заасан ногдол ашиг тараах өдрийг тодорхой зааж өгөх;

4. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд дараах шаардлагыг хангаж ажиллах:

4.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө”, СТОУС 16-ын 32-т “Зарим хөрөнгийн зүйлийн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц, тогтмол өөрчлөлт гардаг бол тэдгээрийг жил бүр дахин үнэлэх шаардлагатай. Үнэ цэнэ нь үл мэдэгдэм өөрчлөлттэй байдаг хөрөнгийн хувьд гурваас таван жил тутам үнэлгээ хийх нь тохиромжтой” гэж заасантай нийцүүлж танай компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд хөрөнгийн үнэлгээ хийлгээгүй бол компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөр Хороонд бүртгэлтэй хөрөнгийн үнэлгээний компаниар хөрөнгийн үнэлгээ хийлгэх асуудлыг хэлэлцэн сонгож, 2021 оны хоёрдугаар улиралд багтаан хөрөнгийн үнэлгээ хийлгэн, холбогдох өөрчлөлтүүдийг санхүүгийн тайландаа тусгаж, дүгнэлтийг Хороонд 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлантай хамт ирүүлэх;

4.2 Хороонд бүртгэлгүй аудитын компаниар компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэсэн тохиолдолд Хороо хүлээн зөвшөөрөхгүй болохыг анхаарах;

4.3 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор 2021 оны хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хороо болон хөрөнгийн биржид цаасаар ирүүлэх.

5. “Компанийн засаглалын кодекс”-ийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар тайлбар, холбогдох материалыг ирүүлэх.

6. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д “Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг хэлнэ” гэж тодорхойлж өгсөн. Мөн компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг “Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг компанийн хувьцааны хяналтын багц гэнэ” гэж компанийн шийдвэр гаргахад ихээхэн нөлөө бүхий байдлыг илтгэх “хяналтын багц эзэмшигч” гэдгийг тодорхойлж өгсөн ба эдгээрийн мэдээллийг журамд заасан хугацаанд ирүүлэх.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлээгүй, Компанийн тухай хуульд заасан тайлан тэнцэл, мэдээ, мэдээллийг нь нийтэд болон эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, мэдээлэх, тайлагнах, мэдэгдэх

үүргээ биелүүлээгүй, ногдол ашиг олгохоор шийдвэрлээд олгоогүй, ногдол ашиг олгохгүйгээр шийдвэрлэсэнээ хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулаагүй хувьцаат компанийг Зөрчлийн тухай хуулийн 10.11 дүгээр зүйл, 11.10 дугаар зүйлд тус тус заасан торгуулийн арга хэмжээ авах нөхцөл үүсэх тул аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллан, дээр дурдсан ирүүлэхийг шаардсан тайлбар, баримт материалыг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг мэдэгдэж байна.

Түүнчлэн хувьцаат компани нь заавал өөрийн цахим хуудастай байх, цахим хуудасны үйл ажиллагааг идэвхжүүлэх, мөн зайнаас хяналт тавихтай холбоотойгоор компанийн албан ёсны цахим шуудангийн хаягаа бичиж ирүүлэх шаардлагатай ба цаашид шаардлагатай зарим мэдээлэл, албан бичиг, мэдэгдлийг албан ёсны Хороонд бүртгүүлсэн цахим шуудангийн хаягаар хүргүүлж байх болно.

Өгөгдсөн үүрэг даалгаврыг хууль тогтоомж, журам, заавар болон энэхүү албан бичигт дурдсан хугацаанд Хороонд ирүүлээгүй тохиолдолд танай компанитай холбоотой аливаа тодорхойлолтыг гаргаж өгөх боломжгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДОЛГОРСҮРЭН

1. БАГАНУУР, ЗӨБЦТС
2. БАГАНУУРЫН ДЦС
3. ББЭХС
4. БУЛГАН АЗЗА
5. ДАЛАНЗАДГАДЫН ДЦС
6. ДАРХАН УС СУВАГ
7. ДАРХАНЫ ДУЛААН СҮЛЖЭЭ
8. ДАРХАНЫ ДЦС
9. ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН
ҮЙЛДВЭР
10. ДБЭХСҮЛЖЭЭ
11. ДЗУЗГ
12. ДУЛААН ШАРЫН ГОЛ
13. ДЦС-2
14. ДЦС-3
15. ДЦС-4
16. МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
17. МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖ
18. НАЛАЙХЫН ДУЛААНЫ
СТАНЦ
19. ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ
20. СЭЛЭНГЭ АЗЗА
21. ТАЛЫН ЗАМ
22. УЛААНБААТАР АЗЗА
23. УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ
24. УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ
25. ХАРГУЙ
26. ХӨТӨЛИЙН ЦЕМЕНТ
ШОХОЙ
27. ЦДҮСҮЛЖЭЭ
28. ЭРДЭНЭТ УДТС
29. ЭРДЭНЭТ, БУЛГАНЫ
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ
30. ЭРДЭНЭТИЙН ДЦС
31. АВТОИМПЕКС
32. БАГАНУУР
33. БАЯНТЭЭГ
34. МОГОЙН ГОЛ
35. МОНГОЛ ШУУДАН
36. МЦХ
37. ТАВАН ТОЛГОЙ
38. ХАНЫН МАТЕРИАЛ
39. ХИШИГ УУЛ
40. ШИВЭЭ ОВОО
41. АЛТАЙН НЭГДЭЛ
42. АРВИЖИХ
43. АСБИ
44. БАЯН АЛДАР
45. БӨӨНИЙ ХУДАЛДАА
46. ГЕРМЕС ЦЕНТР
47. ДОРНОД ИМПЕКС
48. ЕВРОФЁ АЗИА
49. МАТЕРИАЛИМПЕКС
50. МОНГОЛ ДИЗЕЛЬ
51. МОННАБ
52. МҮДИКС
53. НИЙСЛЭЛ ӨРГӨӨ
54. ОЛЛОО
55. ТАВИЛГА
56. ТЕХНИКИМПОРТ
57. ТӨМРИЙН ЗАВОД
58. ТЭЭВЭР АЧЛАЛ
59. УБ БҮК
60. ХӨСӨГ ТРЕЙД
61. АГРОТЕХИМПЕКС
62. ДӨРВӨН-УУЛ
63. МОНГОЛ СЕКЮРИТИЕС
64. МОНГОЛ ШИЛТГЭЭН
65. ХОРИНХОЁРДУГААР БААЗ
66. ХӨДӨӨГИЙН ТЭЭВЭР
67. ГАН ХИЙЦ
68. МАХИМПЕКС
69. МЕРЕКС
70. МОНГЕО
71. МОНГОЛ КЕРАМИК
72. РЕМИКОН
73. СОНСГОЛОН БАРМАТ
74. СҮҮ
75. ТАВ
76. ТАЛХ ЧИХЭР
77. БАЯНГОЛ ЗБ
78. ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ
79. ГЛОБАЛ МОНГОЛИА
ХОЛДИНГС
80. ГОВЬФАЙНЭНШЛ ГРУПП
/СИЛК НЭТ/
81. ДИЖИТАЛ КАТАЛИСТ
/ЛЮКС ЗАНАДУ
82. ЕВРАЗИА КАПИТАЛ
ХОЛДИНГ
83. МИК ХОЛДИНГ
84. ХАЙ БИ ОЙЛ
85. ЖЕНКО ТУР БЮРО
86. ХОТ ДЕВЕЛОПМЕНТ
87. АПУ

88. АРИГ ГАЛ
 89. АТАР ӨРГӨӨ
 90. БӨХӨГ
 91. ГОВЬ
 92. ГУТАЛ
 93. МОНГОЛ НЭХМЭЛ
 94. МОНГОЛ САВХИ
 95. МОНГОЛ ШЕВРО
 96. МОН-ИТ БУЛИГААР
 97. МОННООС
 98. НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ
 99. СОР
 100. УЛААНБААТАР ХИВС
 101. ХӨНГӨН БЕТОН
 102. ХӨХ ГАН
 103. ШИНЭСТ
 104. БЭРЭН МАЙНИНГ
 105. БАРИЛГА КОРПОРАЦИ
 106. БИ ДИ СЕК
 107. БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ
 108. МОНИНЖБАР
 109. ТАХЬ-КО
 110. УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР
 111. ХҮННҮ МЕНЕЖМЕНТ/
 ХААБ
 112. ХҮРД
 113. АВТОЗАМ
 114. АР БАЯНХАНГАЙ
 115. БОРООГИЙН ҮЙЛДВЭР
 116. ХАСУ МАНДАЛ
 117. АЗЫК
 118. АЧИТ АЛКАБЫ
 119. ТУЛПАР
 120. ЭРЧИМ БАЯН-ӨЛГИЙ
 121. НОМИН ХИШИГ
 122. БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ
 123. БУЛГАН УНДАРГА
 124. ИНГЭТ ТОЛГОЙ
 125. ЭРДЭНЭТ СУВАРГА
 126. БИНСЭ/ БАЯНХАЙРХАН
 127. АЙ ТҮҮЛС
 128. ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ
 129. ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ
 130. ДАРХАН НЭХИЙ
 131. ДАРХАН ХӨВӨН
 132. ДАРХАН ХҮНС
 133. ЖАРГАЛАНТ ҮЙЛС
 134. МОНГОЛ АЛТ
 135. ТҮШИГ УУЛ
 136. ТЭЭВЭР ДАРХАН
 137. ХУРТАЙ
 138. ШАРЫН ГОЛ
 139. Э-ТРАНС ЛОЖИСТИКС
 140. АДУУНЧУЛУУН
 141. БАЯНТАЛБАЙ
 142. ГАН ХЭРЛЭН
 143. ДОРНОД
 144. ДОРНОД АВТО ЗАМ
 145. ДОРНОД ХУДАЛДАА
 146. ХЭРЛЭН ХИВС
 147. ЭРЭЭНЦАВ
 148. ДЭВШИЛ МАНДАЛ
 149. МАНДАЛГОВЬ ИМПЕКС
 150. ЗАВХАН БАЯЛАГ
 151. БҮТЭЭЛЧ ҮЙЛС
 152. НАКО ТҮЛШ
 153. ЭРДЭНЭТ АВТО ЗАМ
 154. ЭРДЭНЭТ ЗАНДАН
 155. ЭРДЭНЭТ ХҮНС
 156. ХАРХОРИН
 157. ШИМТЛЭГ /ХАР ХОРИН
 ПРО/
 158. ГОВИЙН ӨНДӨР
 159. ЖУУЛЧИН ГОВЬ
 160. ГОНИР
 161. ТАЛЫН ГАЛ
 162. Е МОНИЕ
 163. ОРХОН ХӨГЖИЛ
 /ЦУУТАЙЖ/
 164. ЭМ ЭН ДИ
 165. СЭЛЭНГЭ СҮРЭГ
 166. ЦАГААН ТОЛГОЙ
 167. ШИМ
 168. ГУРИЛ УВС
 169. АРД САНХҮҮГИЙН
 НЭГДЭЛ
 170. ИХ БАРИЛГА
 171. УВС ХҮНС
 172. УВС ЧАЦАРГАНА
 173. УЛААН САН
 174. ХАР ТАРВАГАТАЙ
 175. АЛТАЙН ЗАМ
 176. ХӨВСГӨЛ
 177. ХӨВСГӨЛ АЛТАН
 ДУУЛГА
 178. ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ
 179. ХӨВСГӨЛ УСАН ЗАМ
 180. ХӨВСГӨЛ ХҮНС
 181. БЭРХ УУЛ
 182. ӨНДӨРХААН
 183. БАЯНТОЛГОЙ
 184. БОРНУУР

185. БҮТЭЭЛ
186. ГАНТӨМӨРТ
187. ДАВААНБУЛАГ
188. ДОРНОД ТЭЭВЭР
189. ЖИНСТ
190. ЗАВХАН ТЭЭВЭР
191. ЗАВХАН ТЭЭХ
192. ИХ НУУР
193. ИХ ҮҮСГЭЛ
194. ӨЛЗИЙ ДУНДГОВЬ
195. ӨРГӨН ХЭРЭГЛЭЭ
196. СЭЛЭНГЭ АР ХӨВЧ
197. СЭЛЭНГЭ ИМПЕКС
198. УЛИАСТАЙ ТЭГШ
199. УСЖУУЛАХ
200. ЧАНДМАНЬ ДУНДГОВЬ
201. АР ТАРХИ
202. ДАРХАН МАХ ЭКСПО
203. БАЯЛАГ ШАРЫН ГОЛ
204. ЗООС БАНК
205. ДАРХАН СЭЛЭНГИЙН
ЦТС
206. ХАРШИЙН ГЭГЭЭ
207. АЖЛЫН ХУВЦАС
208. САВ ШИМ
209. ТӨВ УС
210. ХАНГАЛ
211. ХҮНС АРХАНГАЙ
212. ЧАНДМАНЬ УУЛ
213. АЛМААС
214. БАЯНТООРОЙ
215. МӨНХ ЖИМ
216. ОРГИЛ ГОВЬ-АЛТАЙ
217. ӨВ УСЖУУЛАГЧ
218. МОНАСАР
219. ХАРГИА
220. ЭСГИЙ ГУТАЛ
221. СИЛИКАТ
259. ЖИМСТ
260. ЖОНШИТ ТЭЭВЭР
261. ЗАЛУУЧУУД
262. ЗҮҮНХАРАА ӨРГӨӨ
263. ИЖ БҮРЭН
264. ИХ ДААЦ
265. МАНДАЛ
266. МЕРЕЙ
267. МОНГОЛ ЭД ИМПЕКС
268. НАЛАЙХ ӨРГӨӨ
269. НОЁН ШАНД
270. ОРХОН
271. ӨРГӨН ЖИМ
222. ДОРНОД НООС
223. АНД ЭНЕРГИ
224. АРД ДААТГАЛ
225. ЛЕНД МН
226. МОНГОЛ БАЗАЛЫТ
227. ТҮМЭН ШУВУУТ ХК
228. ХОВД АЗЗА ТӨХК
229. УВС АЗЗА ТӨХК
230. ЗАВХАН АЗЗА ТӨХК
231. ГОВЬ-АЛТАЙ АЗЗА
232. ИНВЕСКОР ББСБ ХК
233. МОНОС ХҮНС ХК
234. БОДЬ ДААТГАЛ
235. МАНДАЛ ДААТГАЛ
236. АРД КРЕДИТ ББСБ ХК
237. АЗЗАН
238. НОЁТ ХАЙРХАН
239. ОРХОНДАЛАЙ
240. АВТО ТЭЭВЭР-27
241. АВТОДААЦ
242. АГРО-АМГАЛАН
243. АЛТАН ҮСЭГ
244. АЛТАНДУУЛГА
245. АРДЫН ЗОРИГ
246. АСГАТ
247. АТАР ТӨВ
248. БАТ ХИЙЦ
249. БАЯНБАДРАХ
250. БАЯНБУЛАГ СЭЛЭНГЭ
251. БАЯНДӨХӨМ
252. БАЯНМОД УУЛ
253. БАЯНХААН
254. БАЯНХОНГОР "ГЕО"
255. БУЯНТ БУЛАГ
256. ГОВЬ ШАНД
257. ДЭЛ БАЯНБУЛАГ
258. ЖАРГАЛАНТ ТӨВ
272. САЙНШАНД
273. СЭЛЭНГЭ ГУРИЛ
ТЭЖЭЭЛ
274. СЭЛЭНГЭ ХҮРД
275. ТАХИЛГАТ
276. ТУРУУН
277. ТЭЭВЭР ЦАГААННУУР
278. УВС
279. УГТААЛ/ТӨВ
280. УС АРХАНГАЙ
281. ХАЛХ БУУДАЙ
282. ХАНГАЙ
283. ХАНГАЙН ЦАРАМ

284. ХУЖИРТ ӨРГӨӨ
285. ХҮНС ТӨВ
286. ЦАГААННУУР
287. ЦАГААНЧУЛУУТ
288. ЧАНДГАНА
289. ШАР ХООЛОЙ
290. ШАХАЙТ ХАЙРХАН
291. ШИНЭ ӨРГӨӨ
292. ЭРДЭНЭТОЛГОЙ ТӨВ
293. АЛТАЙ ХАНЫН МАТЕРИАЛ
294. ГОВЬ СҮМБЭР
295. ДАР ЗАМ
296. ЖИНЧИН
297. МАНДАЛ ОРГИЛ
298. СҮМБЭР ӨЛЗИЙ
299. ТОРГОН ҮР
300. ТЭЭВЭР ТӨВ
301. УВС АРИЛЖАА
302. УЛААНХОТГОР
303. УЛБАА
304. БАЯНЧАНДМАНЬ АЗЗА ТӨХК
305. ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ ХК
306. МОНГОЛ ДААТГАЛ /ХОРГО ХАЙРХАН/
307. ЭРДЭНЭТ. БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
308. ХОВД ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК
309. ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК
310. ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК
311. АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК
312. ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ
313. АРИЛЖАА ИМПЕКС/СТАНДАРТ НООС
314. СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП
315. ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ /БАЯЛАГ СҮМБЭР/
316. МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ
317. СТАНДАРТ ПРОПЕРТИЕС/ БАЯНБОГД
318. ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП /МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС/